




ХИЧЭЭЛ 2

УНШИХ ЗҮЙЛС: ҮЙЛС 6:1-7; ДАГАЛДАГЧДЫН ҮЙЛС, Х. 87-96.

Онцгой Долоон Туслагч

Та нар аавтайгаа эсвэл ээжтэйгээ хамтдаа хоол хийх эсвэл машин угаах дуртай юу? Хамтдаа ажиллах бүр илүү сайхан байдаг шүү дээ. Олон жилийн өмнө хэдэн хүн дагалдагчид туслахаар онцгойлон сонгогджээ.



нэ одоо юун чимээ шуугиан вэ?" гэж Петр асуув.

Матай санаа алдан, "Зарим шинэ итгэгч нар дахиад л хоорондоо маргаж эхэллээ" гэж хариуллаа.

"Тэд юундаа маргасан юм болоо?" хэмээн

Петрийг асуухад "Яахав дээ, Грек хэлээр ярьдаг шинэ итгэгч нар тэдний бүлэгт байгаа бэлэвсэн эмэгтэйчүүд еврей бэлэвсэн эмэгтэйчүүд шиг хангалттай идэх юм тусламж болгон авахгүй байна гэж гомдоллоод байгаа юм" хэмээн Матай хариулаад санаа алдав. "Тэдний маргалдахыг дахин сонсох ямар хэцүү юм бэ?"

"Маргалдах гэдэг бол буруу зүйл. Их Эзэн маань хүүхдүүдээ ийнхүү маргалдаж байхыг огтхон ч хүсдэггүй. Есүст итгэдэггүй хүмүүст Түүний хайрыг харуулах зүйл бол энэ огт биш гэдэг нь ойлгомжтой. Хүмүүсээ дуудаад ер нь энэ талаар юу хийж болох талаар ярилцъя."



Цээжлэх Ишлэл:
"Ариун хүмүүсийн хэрэгцээнд хандив өргө"

РОМ 12:13.

Тол санаа:
Бурханы хүмүүс бусдад туслахын тулд хамтдаа ажилладаг.

Ингээд дагалдагчид ярилцсан ёсоороо Есүст итгэгчдийг бүгдийг нь нэг дор цуглуулаад босож үг хэлэв. "Дагалдагчид бид та нарын хоол ундны асуудлыг шийдэхийн тулд Бурханы үгийг заах сургах ажлаа зогсоохыг хүсэхгүй байна" гэж тэд яриагаа эхэллээ. "Бид арга бодож олсон. Бид одоо мэргэн ухаантай долоон хүнийг сонгоно. Ариун сүнсээр дүүрсэн ухаантай хүмүүсийг сонгох болно. Тэд хоол ундны асуудлыг шийддэг байх болно. Хүн бүрийг хэрэгтэй хоол ундаар нь хангадаг байх асуудлыг тэд хариуцах болно."

Итгэгчид бие бие рүүгээ хараад инээмсэглэв. Үнэхээр сайхан санаа байсан юм.

Дараа нь итгэгчид долоон хүнийг сонгох болов. Харин тэд сонголтыг маш болгоомжтой хийсэн юм. Мэргэн ухаантай бас Ариун сүнтэй хүмүүсийг тэд сонгожээ. Тэдний сонгосон хүмүүс шударга бас итгэлтэй хүмүүс байлаа. Ингээд тэд Стефен, Филип, Прохор, Никанор, Тимон, Пармен болон Никол нарын долоон хүнийг сонгов.

Дагалдагчид сэтгэл хангалуун байлаа. Тэд долоон хүнийг тойрч зогсоод толгой дээр нь гараа тавьж залбирав. Тэд одоо Бурханы төлөө тусгай ажил хийхээр сонгогдлоо гэсэн үг. Тэд бэлэвсэн эмэгтэйчүүдийг асарч хандахад маань туслаач гэж тэд Бурханаас гуйжээ.

Ингээд төлөөлөгчид илүү олон хүнд Есүсийн тухай ярьж, сургах боломжтой боллоо. Улам олон хүн Бурханы үгийг сонсов. Олон хүн Есүст итгэсээр л байсан юм. Янз бүрийн хүмүүс итгэгчид болжээ. Дэлгүүрийн эздээс эхлээд фермерүүд хүртэл, нэхмэлчдээс эхлээд углааш хийгчид. Тэр ч байтугай сүмийн зарим зэрэгтнүүд хүртэл Есүст итгэжээ.

Бурханы гэр бүлд хүн бүхэн нь маш чухал. Хоол хүнс хэрэгтэй байсан бэлэвсэн эмэгтэйчүүд одоо хайр халамжаар дутахгүй боллоо. Бид ч бас Бурханы туслагчид байж чадна. Хоолгүй байгаа хүмүүст та нар хэрхэн тусалж чадах вэ?



Дасгал Ажил

ШАББАТ

Энэ долоо хоногийн өдөр бүр хичээл дээр үзсэн түүхээ уншаад цээжлэх ишлэлээ давтаарай.

Ариун хүмүүсийнБусад руу заах.

хэрэгцээнд.....Гараа сунгахдаа гунигтай царай гаргах.

хандив өргө.....Юм тарааж өгөх мэт байдал үзүүлэх.

Ром 12:13Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

НЯМ

Шаббат хичээлээс авчирсан Туслагчийн албан ёсны сертификатаа сүмийн хэн нэг гишүүнтэй хуваалцахад нь хүүхдээ урамшуулаарай. Хүүхдээ түүнд ямар нэг зүйл хийлгэж туслуулаарай. (урмын үг захидал илгээх, хашаа цэвэрлэх, хоол хүргэж өгөх, дуу дуулж өгөх г.м.)

ДАВАА

Дагалдагчид хэдэн туслагч сонгосон бэ? (долоо) Бусдад туслах долоон арга бодож олоход нь хүүхдэдээ туслаарай.

Хүүхэдтэйгээ хамт гэр орны ажил хийгээрэй. Хамтдаа байхад хичнээн амархан байгааг ярилцаарай. Дагалдагчид болон туслагчдын тухай ярьж өгөөрэй.

МЯТМАР

Хүүхдээсээ асуух: Хэрэв хоёр хүнд ганц жигнэмэг байвал ямар нэг маргаан гарах уу? Чи маргаан гарвал яаж шийдэх вэ? Та нар юуны талаар



маргадаг вэ? (хаана суух вэ, тоглоомоор хэн тоглох вэ г.м.) Асуудлыг шийдэхэд нь туслаарай.

Залбирахаасаа өмнө халамж тавих тухай дуу дуулаарай.

ЛХАГВА

Үйлс 6:1-7 -г хамтдаа уншаарай. Асуух: Чи бусдад тусалдаг уу? Бэлэвсэн эмэгтэйчүүд сонгогдсон долоон хүний талаар юу гэж бодсон бол? Хүүхдээрээ өөрийгөө хооллуулаарай. Зарим хоолыг өөртөө идүүлээрэй. Дараа та хүүхэддээ хоол өгөөрэй. Асуух: Бусдад туслах чамд ямар санагддаг вэ? Эсвэл тусламж авахад?

ПҮРЭВ

Хэн нэг өвчтэй хүнд хүүхдээрээ юм бэлдүүлнэ үү? Хүүхэдтэйгээ хамт өвчтөн эмч болж тоглоорой. Хүүхдээрээ үзүүлээд боолгуулаарай. Тэр долоон туслагч хэрхэн өвчтэй хүмүүсийг асарч байсан тухай ярьж өгөөрэй. Сүмийнхээ өвчтэй байгаа хүний төлөө залбираарай.



БААСАН

Гэрийнхэнтэйгээ хамт Библийн түүхийг жүжиглээрэй. Долоон туслагчийг долоон тоглоомоор орлуулаарай. Таныг туслагчдын нэрийг уншиж байхад хүүхэд тань тоглоомуудыг нэг нэгээр нь зааж томилно.